Хүчтэй цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах

СЭДЭВ: Хүчтэй цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах

ЗОРИЛГО:

Цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх аргад суралцах, бэлтгэл бэлэн байдлаа хангах мэдлэгтэй болох.

АГУУЛГА:

- Цасан шуурганы тухай ерөнхий ойлголт
- Түүх
- Шороон шуурганы тухай ерөнхий ойлголт
- Түүх
- Тоон мэдээ
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Бататгах

Агаарын хэвтээ чиглэлийн хөдөлгөөнийг **САЛХИ** гэнэ.

Хүчтэй салхи

Салхины хурд 16 м/с түүнээс их, 3 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх агаарын урсгал

Хүчтэй цасан шуурга

Салхины хурд 12 м/с ба түүнээс илүү алсын бараа 2000 м-ээс бага болж 3 цаг ба түүнээс дээш хугацаагаар цасаар шуурах цаг агаарын үзэгдэл

Хүчтэй шороон шуурга

16 м/с түүнээс дээш хүчтэй салхины улмаас элс, шороо их хэмжээгээр агаарт хөөрөн, үзэгдэх орчинг хязгаарлаж эрс муутгах агаар мандлын үзэгдэл

САЛХИНЫ ХУРД, ХҮЧНЭЭС ХАМААРЧ ДАРААХ БАЙДЛААР АНГИЛНА

Салхины хурд м/с	Нэршил	Салхины илрэх шинж ба учруулах аюул	Цаг агаарын мэдээгээр хүргэх хэлбэр
1-14 хүртэл	Зөлөөн	Навчис сэржигнэж, нарийхан мөчир туялзана. Өвсний толгой найгалзана. Туг, дарцаг дэвэлзэнэ. Цаас хийснэ. Шороо босно. Дээлийн хормой дэрвэнэ.	“Цэнхэр залаа” аятайгаар салхины хурдыг зааж зарлана.
15-29	Хүчтэй	Барилгын муудсан болон хөнгөн материалаар хийсэн дээвэр, тоосгон яндан нурна. Мод тахийж мөчир нь хугарна.	“Цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гэсэн тайлбартайгаар салхины хурдыг зааж зарлана.
30-аас дээш	Аюултай	Мод, байшин, гэр, хашаа нурна. Хүн, жижиг мал ойчно. Гэр нурна. Тэнгэр харанхуйлна.	“Харанга” дохиотойгоор “Цаг агаарын нэн аюултай буюу гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ” гэсэн тайлбартайгаар салхины хурдыг зааж зарлана.

Хүн болон байшин барилгад үзүүлэх салхины нөлөөлөл

5-10 м/с Сул шороо тоос бага зэрэг босч эхэлнэ. Усан дээр долгион үүснэ.

10-15 м/с Модны бүдүүн мөчрүүд савлана. Нарийн мод бүхэлдээ ганхана. Шинэ орсон цас хийсэж эхэлнэ.

15-18 м/с Модны нарийн мөчрүүд хугарч, салхи сөрж явахад төвөгтэй болно.

18-22 м/с Байшингийн хөнгөн дээвэр хуурна.

22-25 м/с Модыг үндсээр нь булга татна. Гэр хөнгөн хийц бүхий байшин, хашаа саравч нурна

25-29 м/с Байшин барилгад багагүй эвдрэл учирна.

30 м/с-ээс их Асар их эвдрэл учруулна.

ЦАСАН ШУУРГА

Газрын гадарга орчимд салхины хурд тодорхой хэмжээнд хүрэхэд шинэхэн орсон цас салхинд хийсэх үзэгдлийг **ЦАСАН ШУУРГА** гэнэ.

Намын шуурга

/ Цас орж байх үед 7 м/сек-ээс дээш хүчтэй салхинд цас газрын гадаргаас дээш хэдэн метрийн өндөрт хийсэх үзэгдэл/

Орон шуурга

/Шинэхэн орсон сэвсгэр цас 10-12 м/сек-ээс дээш хүчтэй салхинд газрын гадаргаас дээш хэдэн метрийн өндөрт хийсэх үзэгдэл/.

Явган шуурга

/Шинэхэн орсон сэвсгэр цас 10-12 м/сек-ээс дээш хүчтэй салхинд газрын гадаргаас дээш хэдэн метрийн өндөрт хийсэх үзэгдлийг намын шуурга гэнэ.

ШОРООН ШУУРГА

Хүчтэй салхитай үед тоос, шороо их хэмжээгээр агаарт хөөрч, түүний улмаас агаар булингартан алсын барааны харагдалтыг эрс муудуулдаг үзэгдэл”

“Цэлмэг эсвэл багавтар үүлтэй өдөр газрын гадарга дээр үүссэн агаарын хуйлрах хөдөлгөөний дагуу боссон шороо, тоосыг хуй



Явган шороон шуургыг “салхинд шороо, тоос газрын гадарга дагуу 2 метр хүртлэх өндөрт

Цасан болон шороон шуурганы болох хугацаа

Цасан шуурга хүйтний ба шилжилтийн улиралд (10-4 сард) зонхилон ажиглагдаг . монгол орон цасан шуургатай өдрийн тоо дунжаар жилд 1-12 байдаг .

Хүчтэй салхи, түүнийг дагалдан үүсдэг шороон шуурганы давтагдал жил бүрийн хавар ихэсдэг.

ХҮЧТЭЙ ЦАСАН ШУУРГАНЫ УЛМААС ХОХИРОЛ УЧИРСАН ТОМООХОН ЖИШЭЭ:

1993 оны 5 дугаар сарын 5-6-нд манай орны төв, баруун зүгийн нутгийг хамарсан хүчтэй цасан шуурга шуурснаас 100-гаад мянган мал хорогдож, 16 хүний амь насаа алдсан.

СҮҮЛИЙН 13 ЖИЛИЙН ХУГАЦААНД УЛСЫН ХЭМЖЭЭНД ТОХИОЛДСОН ХҮЧТЭЙ САЛХИ, ШУУРГАНЫ ТОХИОЛДЛЫН ТОО



Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт

№	Үзэгдлийн нэр, ангилал	Аюултай үзэгдэл	Үргэлжлэх хугацаа	Гамшигт үзэгдэл	Үргэлжлэх хугацаа
1	Хүчтэй салхи	Салхины дундаж хурд 18 м/с, түүнээс их (өрөвхийлэлт 24 м/с түүнээс их)	Хугацаа хамаарах гүй	Салхины дундаж хурд ойт хээр, уулархаг нутагт 24 м/с, тал хээр, говь цөлийн бүсэд 28 м/с, түүнээс их (Өрөвхийлэлтийн хурд 34 м/с болон түүнээс их)	Хугацаа хамаарахгүй
2	Цасан шуурга	Салхины дундаж хурд 10 м/с болон түүнээс их үед цасан шуурга шуурч алсын бараа 2000 м-ээс бага болох	3 цаг, түүнээс дээш	Салхины дундаж хурд 16 м/с (өрөвхийлэлт 20 м/с болон түүнээс их, алсын бараа 2000 м-ээс бага болох	6 цаг, түүнээс дээш
3	Шороон шуурга	Алсын барааны харагдац 1000 метр болон түүнээс бага болох	3 цаг, түүнээс дээш	-	-

ЦАСАН БОЛОН ШОРООН ШУУРГАНААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ



1. *Цаг агаарын мэдээ тогтмол сонсох*

2. Хүчтэй салхи, шуурга болох мэдээ авсан бол гэр орон сууцаа бэхлэх, дулаан алдалтыг багасгах.
3. Худаг усыг хамгаалах, нөмөр нөөлөг газруудыг тогтоох, түүнийг хүн бүх мэддэг байх.

4. Сэрэмжлүүлэг мэдээ хүлээн авсан тохиолдолд аян замд гарахаас зайлс хийх.

5. Аян замд зайлшгүй аян зам шаардлагатай үед техникийн бүрэн бүтэн байдлыг шалгаж аюулүй байдлаа хангах.

6. Өндөр хүчдэл, цахилгааны шугаман дор гэр, суудаа барихгүй байх.

7. Хоол хүнс, ундны ус, түлш, анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм тариа, ариун цэврийн хэрэглэл, дулаан хувцас бэлтгэх.

ХҮЧТЭЙ ЦАСАН БОЛОН ШОРООН ШУУРГАНД ТӨӨРСӨН, ЭД ХӨРӨНГӨ АЛДСАН ХҮМҮҮСИЙН ИХЭНХ ХУВЬ НЬ ЦАГ АГААРЫН СЭРЭМЖЛҮҮЛЭХ МЭДЭЭ ХҮЛЭЭН АВСАН БОЛОВЧ ЗААВАР ЗӨВЛӨМЖИЙГ БИЕЛҮҮЛЭЭГҮЙГЭЭС ХОХИРОЛ АМСАН БАЙДАГ.

..... ТА ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛҮҮДИЙГ ТООЧООД АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГААРАЙ.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

УГТАЖ ХАР, ТОСОЖ БЭЛД, ТЭСЭЖ ДАВ

ЧИНГИС ХААН

ANHAAR APP

- Гамшиг, ослын үед авах арга хэмжээ
- Холбоо барих байгууллагууд болон утасны дугаарууд
- Амилуулах суурь тусламжийн зааврууд
- Гамшиг, ослын үед ашиглах хэрэгслүүд

Available on the App Store

ANDROID APP ON Google play